

**Аймгийн удирдах ажилтнуудын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2024.02.16

Чойр хот

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1	Сар шинийн баярын өдрүүдэд “Хариуцлагатай жижүүр”-ийн үүргийг хуваарийн дагуу өөрийн биеэр хийж гүйцэтгэх.	2024.02.10-12-ны өдрүүдэд	2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/04 дугаар тушаалаар сар шинийн баярын өдрүүдэд “Хариуцлагатай жижүүр”-ийн үүргийг томилогдсон 12 удирдах албан тушаалтан 100 хувь гүйцэтгэсэн.	100
2	Сар шинийн баярын нийтийн золголтын арга хэмжээнд байгууллагын удирдлагууд оролцох	2024.02.10-ны 11:00 цагт	Шинийн нэгэнд зохион байгуулагдсан нийтийн золголтын арга хэмжээнд 10 байгууллагын удирдах албан тушаалтан оролцсон. Оролцсон удирдах албан тушаалтнууд: Сүмбэр сумын Засаг дарга Боржигин чуулга 2 дугаар цэцэрлэг Хүнс, хөдөө аж ахуйн газар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар Байгаль орчин, аялал жуулчлалын газар Соёл урлагийн газар Насан туршийн боловсролын төв Сум дундын ойн анги Улсын_ бүртгэлийн хэлтэс	70
3	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн Онцгой комиссын шийдвэрээр хөдөө гэртээ туслах төрийн албан хаагчдад цалинтай чөлөө олгосон талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулах	2024.02.19	Хөдөө малтай, гэр бүлдээ туслах хүсэлтэй 14 байгууллагын 62 алба хаагчдын судалгааг нэгтгэн аймгийн Онцгой комисст танилцуулсан. Үүнээс 9 байгууллагын 26 албан хаагчид цалинтай чөлөө олгосон. Үүнд: - Шивээговь сум 15 албан хаагчид - Баянтал сум 3 албан хаагчид - Боржигин өв музей 1 албан хаагчид - Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 1 албан хаагчид - Стандарт хэмжил зүйн газар 2 албан хаагчид - Улсын бүртгэлийн хэлтэс 1 албан хаагчид	70

			<ul style="list-style-type: none"> - Байгаль орчин, аялал жуулчлалын газар 1 албан хаагчид - Соёл урлагийн газар 1 албан хаагчид - Ус, цаг уур, орчны шинжилгээний газар 1 албан хаагчид тус тус цалинтай чөлөө олгосон. 	
4	Нийтийн хоол үйлчилгээ эрхлэгч болон хүнсний бүтээгдэхүүн худалдах эрх бүхий аж ахуй нэгжүүдэд мэргэжлийн байгууллагууд чиглэл чиглэлийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	2024.02.19	<p>“Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Эрүүл мэндийн болон Мал эмнэлэг, эрүүл ахуйн улсын байцаагч нар Сүмбэр, Шивээговь сумдын хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл эрхлэж буй 14 цэгт хамтарсан хяналт шалгалт хийж хугацаа дуусч чанар аюулгүй байдал нь алдагдсан 4 нэр төрлийн 78 ширхэг, 2.94кг, нийт 734641 төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүн (мах, махан болон сүү, сүүн бүтээгдэхүүн)-ийг илрүүлж, устгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.</p> <p>Мөн эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн улсын байцаагч худалдаа үйлчилгээний 15 газарт хяналт шалгалт хийж, хадгалалтын горим хангаагүйгээс эрүүл ахуйн шаардлага хангаагүй 9 нэр төрлийн 174 ширхэг 152 литр 1256950 төгрөгийн түргэн гэмтэх бүтээгдэхүүнийг газар дээр устгаж, бүтээгдэхүүнийг актаар хурааж авч хүнсний сүлжээнээс хасав.</p>	100
5	Малын сэг зэм, хог хаягдал устган цэвэрлэх ажлын төсвийн тооцоог гаргаж, холбогдох байгууллагууд бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж хамтарч ажиллах	2024.03.04	<p>Сүмбэр сумын Засаг даргын 2024 оны 02 сарын 15-ны өдрийн А/56 дугаар захирамжаар “Ариутгал халдваргүйжүүлэлт, сэг зэм устгах ажилд хяналт тавих” ажлын хэсгийг байгуулж, сэг зэм цуглуулж устгах байршил цэгийг тогтоосон бөгөөд 02 сарын 19-ноос сэг зэм цэвэрлэх ажлыг эхлүүлнэ.</p> <p>Шивээговь сум 2024 оны 02 сарын 9-нд Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэгтэй хамтран улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу сумын төвийн ойр орчимд байсан үхсэн малын сэг, зэмийг зайлуулах, устгах ажлыг зохион байгуулж, 2.1 тн сэг</p>	ХБ

			<p>зэмийг устгасан. Цаашид сэг зэм усгах арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж байна.</p> <p>Баянтал суманд малын сэг зэм хягдал урьдчилсан байдлаар маш ихээр олон газарт тархацтай байна. Иймд нарийн тооцоолол гаргахаар ажиллаж байна.</p>	
6	<p>“Малчдад тусалъя” аянд нэгдэн дэмжлэг үзүүлсэн иргэд болон аж ахуй нэгж байгууллагыг нийтэд зарлаж, алдаршуулах</p>	2024.02.19	<p>“Малчдад тусалъя” аяны хүрээнд Сүмбэр сум 02 сарын 16-ны байдлаар 14 албан байгууллага 5740.0 мянган төгрөг бэлнээр, 18 албан байгууллага, аж ахуйн нэгж 5902.7 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүн, дулаан хөнжил, нэмнээ, тэжээл, өвс зэрэг нийт 8 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн хандивлаад байна.</p> <p>Хандиваар ирсэн 5400,0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг хүнд нөхцөлд байгаа 137 өрхөд хүргүүлээд байна.</p> <p>Мөн бэлнээр ирсэн 3980,0 мянган төгрөгийг шатахууны толон болгон хөдөөгийн багийн Засаг дарга нар болон 28 бүлэгт олгосон.</p> <p>Аянд нэгдсэн албан байгууллага аж ахуйн нэгжийг тухай бүр нь “Сүмбэрийн мэдээ” цахим хаягаар олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Шивээговь сумын 10 байгууллага, 1 сурагч 168 шуудай тэжээл, 25 нэмнээ, 36 шуудай гурил, 100.000 төгрөг, нэмнээ болон ажлын бээлий, ахуйн хэрэгцээний барааг тус тус хандивлаад байна.</p> <p>Баянтал сумын 5 байгууллага 2940.0 мянган төгрөг хандивлаж, 93 малчин өрхөд хуваан шатахуун байдлаар олгохоор төлөвлөж байна.</p>	70
7	<p>Өвс, тэжээлийн нөөцийг хуулийн хүрээнд бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, худалдан авалтыг яаралтай зохион байгуулах</p>	2024.03.04	<p>Аймгийн хэмжээнд 90 тонн өвс байна. 2024 оны нөөцийг бүрдүүлэхээр тендер шалгаруулах ажлын бэлтгэл хийгдэж байна.</p> <p>Шивээговь сумын ЗДТГ аюулгүйн нөөцөд 60 тн өвс, 2.5 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлэхээр шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Сүмбэр сумын ЗДТГ Пример Агро ХХК-аас хорголжин тэжээл 850.000 төгрөг, Тэжээлийн хивэг 800.000 төгрөг, Орос овьёос 1.100.000 төгрөгийн дүнгээр худалдан авах санал ирснийг малчдад хүргүүлсэн бөгөөд сумын аюулгүйн нөөцөд 7.3 тн хорголжин тэжээл</p>	30

			авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
8	Хоршоо хөгжүүлэх сангийн орлогын хуваарилалтын талаарх мэдээллийг танилцуулах	2024.02.19	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 56 хувьтай, 316.7 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн. Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 117 хувьтай, 24.7 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн. Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 130 хувьтай, 52.0 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн.	100
Дундаж хэрэгжилт				77.1

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:

ХШҮХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа